

ШАЛГАЛТАД ОРОЛЦОГСДОД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

ШАЛГАЛТЫН ӨМНӨ

- Шалгалтын талаарх бүх мэдээллийг энэ цахим хуудаснаас уншина уу.
- Та шалгалтын хэлбэртэй танилцана уу. Шалгалт дээр танаас юу хүсэн хүлээж байгааг мэдэх хэрэгтэй. Шалгалт яаж явагддаг болон хариултаа хаана бичихээ хараарай.
- Та чех хэлнийхээ төвшинг өөрөө тодорхойлоорой.
- Хэрэв та шалгалтаа амжилтгүй өгвөл чех хэлний сургалтад хамрагдаж, шалгалтад бэлдэх хэрэгтэй.
- Та шалгалт өгөх өдөр болон сургуулиа сонгоорой. Сургуулиас шалгалтын өдөр цагийг товлох бөгөөд та сул цагаас сонгоно гэдгийг анхаарна уу!
- Шалгалт болохоос хэд хоногийн өмнө та бүртгүүлэхдээ дараах мэдээллийг бөглөнө үү: нэр, овог, паспортын дугаар, хүйс, улсын харьяалал, БНЧУ-д бүртгүүлсэн хаяг, төрсөн он сар өдөр, төрсөн газар, утасны дугаар болон и-мэйл хаяг.
- Шалгалтад орохын өмнө та сургуульд (хэрэв танд байгаа бол) Үнэмлэхээ тушаах эсвэл шалгалтын төлбөрийг төлөх ёстой.
- Шалгалтын үеэр өвдвөл та уучлал гуйх шаардлагатай. Өвчин эмгэгээс бусад шалтгааныг хүлээн авахгүй. Танд эмчийн магадалгаа байх ёстой.

ШАЛГАЛТЫН ӨДӨР

- Шалгалт өгөх өдөр бүртгүүлэхдээ гадаад паспортаа үзүүлнэ.
- Дараа нь ирцийн бүртгэлд гарын үсэг зурах ёстой.
- Хэрэв та шалгалтад хоцорч ирсэн бол тухайн өдөр шалгалт өгөх боломжгүй; дараа нь шалгалт зохион байгуулагчтай өөр өдөр цагийг тохиролцох хэрэгтэй.
- Бүртгүүлэхдээ бүртгэлийн дугаар бүхий карт авах бөгөөд уг дугаарын дагуу та бүх шалгалтаа өгнө.
- Шалгалтын танхимд орсны дараа шалгагч таны суух ширээг зааж өгнө. Та заасан ширээн дээр гадаад паспорт болон бүртгэлийн дугаар бүхий картыг тавих бөгөөд эдгээр нь бичгийн шалгалтын туршид ширээн дээр байх ёстой.
- Шалгалтын танхимд гар утсаа заавал унтраасан байх ёстой.
- Үүнээс гадна та цүнх, ном, тэмдэглэлийн дэвтэр, бичлэг хийх төхөөрөмж, гар утас болон бүх цахим хэрэгслээ бусдад харагдахаар, гэхдээ таны ойр биш газар тавих хэрэгтэй.
- Бичгийн шалгалтын үеэр та өрөөнөөс гарч болохгүй тул шалгалтын бичгийн хэсэг эхлэхээс өмнө бие засахыг зөвлөж байна.
- Та зөвхөн сургуулийн ажилтны зааврын дагуу шалгалтын танхимд орж болно.
- Шалгалтын бичгийн хэсэг тус бүрийн дараа та даалгавар болон бөглөсөн хариултын хуудсыг хураалгана. Шалгалтын бичгийн хэсгийн төгсгөлд бүртгэлийн дугаар бүхий картыг өгнө.
- Бичгийн шалгалтын үеэр бичгийн шалгалтын дүнтэй хэзээ, хаана танилцаж болох талаар мэдээллийг өгнө.

- Хэрэв та бичгийн шалгалтад унавал шалгалтыг өөр хуваарьт өдрүүдэд дахин өгч болно. Та дахин шалгалт бүрийг төлөх ёстой.
- Бичгийн хэсгийг амжилттай өгсний дараа аман шалгалтад ямар дарааллаар орохыг хэлж өгнө. Хүндэтгэн үзэх шалтгаантай, жишээлбэл жирэмсэн эмэгтэйчүүд аман шалгалтыг түрүүлж өгнө.
- Сургуулийн ажилтнууд танд аман шалгалт хэдэн цагт, хаана явагдахыг мэдэгдэнэ. Аман шалгалтад та товлосон цагийг баримтлан цагтаа ирэх ёстой.
- Аман шалгалт явагдаж буй танхимд орохоос өмнө та гадаад паспортаа үзүүлэх ба бүртгэлийн дугаар бүхий картыг дахин авна.
- Аман шалгалт дууссаны дараа та дүнгээ хүлээнэ.

ШАЛГАЛТЫН ДАРАА

- Аман шалгалтаа та амжилттай өгсөн бол танд чех хэлний мэдлэгийг тодорхойлсон Гэрчилгээг олгоно.
- Хэрэв та аман шалгалтад унавал шалгалтыг өөр хуваарьт өдрүүдэд дахин өгч болно. Та дахин шалгалт бүрийг төлөх ёстой.
- Хэрэв та тухайн сургуульд дахин шалгалт өгөхийг хүсэж байвал дараагийн шалгалтын сул хуваарьт шууд бүртгүүлэхийг зөвлөж байна.
- **Шалгалтын дүрмийн үндсэн дээр шалгалтын баримт бичгийг биечлэн үзэж болохгүй, өөрөөр хэлбэл та шалгалтын даалгавар төдийгүй хариултын хуудсыг ч харах боломжгүй гэдгийг анхааруулж байна!**